



**“ИХМОНГОЛ ХӨЛӨГ
АУДИТ” ХХК**

“ЭРДЭНЭТ СУВРАГА” ХК

**АУДИТЛАГДСАН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Тасалбар болсон хугацаа:
2024.12.31

Утас☎:+976 7000-1778

Утас☎:+976 9906-1771

Утас☎:+976 9977-7839

Ажлын байрны хаяг📍: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2 дугаар хороо, 8 дугаар/Тэнхлэг зуучийн/ байр 10 давхар 1003 тоот

Мэйл хаяг✉: info@imkaudit.mn

Улаанбаатар хот
2025 он

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

“Эрдэнэт Суварга” ХК-ийн захирал Н.Одонбилэг, нягтлан бодогч Б.Батчимэг бид энэхүү тайланд үзүүлсэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээ, санхүүгийн тайлангийн тодруулгыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв бодитой, илэрхийлсэн болохыг баталж байна.

ЗАХИРАЛ

Н.ОДОНБИЛЭГ

Огноо: 2025 оны 04 дугаар сарын.....-ны
өдөр

НЯГТЛАН БОДОГЧ

Б.БАТЧИМЭГ

Огноо: 2025 оны .. дүгээр сарын ...-ны
өдөр



“ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ” ХХК
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТ БИЗНЕС ЗӨВЛӨГӨӨ

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2 дугаар хороо,
Төмөрчний гудамж, 8 дугаар байр, 1003 тоот
Утас: (+976) 7000 – 1778, Утас: (+976) 7000 – 1778,
И-мэйл: info@imkaudit.mn, Веб хуудас: www.imkaudit.mn

2025. 04.22 № 0/2025/23

Танай _____-ны № _____-т

**ХАРААТ БУС АУДИТОРЫН
ДҮГНЭЛТ**

Зөрчилгүй дүгнэлт

Бид “Эрдэнэт суврага” ХК (цаашид “Компани”гэх)-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд, Компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн, шударгаар толилуулсан байна гэж дүгнэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт(‘АОУС’)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тайлбарласан. Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу Бид компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь компанийн удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад санхүүгийн тайлангуудыг залилан юм уу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүйгээр бэлтгэж, шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтын системийг зохиож, хэрэгжүүлэн, түүнийгээ тууштай ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож, хэрэглэх, нөхцөл байдалд тохируулан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх зэрэг зүйлс багтана.

Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэдэг.

Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудыг баримталж, санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгодог бөгөөд үүнд, залилан юм уу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдэлийн тооцооллыг хийхтэй холбоотойгоор, аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг сонгож хэрэглэх зорилгоор компанийн санхүүгийн тайланг бэлтгэж, шударгаар толилуулахад зориулан хэрэглэж байгаа дотоод хяналтыг авч үздэг. Мөн санхүүгийн тайлагналыг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллуудын үндэслэлтэй байдал, хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан. Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж бид итгэж байна.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайлан нь Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно.

Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлээхгүй болно.

Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан

Түүнчлэн, санхүүгийн тайланг бэлтгэхдээ Монгол улсад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд болон Сангийн Сайдын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн заавартай нийцэж байна.

ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид

Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо: 2025 оны 04 дүгээр сарын 22



ЭРДЭНЭТ СУВРАГА ХК

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн

Санхүү байдлын тайлан

Үзүүлэлт	2023.12.31.	2024.12.31.
/төгрөгөөр/		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	18,693,816.79	865,338,527.04
Дансны авлага	277,432,255.80	683,370,280.72
Бусад авлага	-	1,500,000.00
Бараа материал	948,377,101.36	10,063,968.20
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	75,315,584.13	27,690,851.13
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,319,818,758.08	1,587,963,627.09
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	2,287,618,870.62	2,198,153,256.19
Биет бус хөрөнгө	4,634,500.01	4,234,590.29
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,292,253,370.63	2,202,387,846.48
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,612,072,128.71	3,790,351,473.57
Дансны өглөг	335,309,410.61	-
Татварын өр	91,251,268.17	381,757,019.47
Богино хугацаат зээл	59,973,800.00	215,000,000.00
Ногдол ашгийн өглөг	780,270.00	-
Урьдчилж орсон орлого	-	21,765,390.00
Бусад богино хугацаат өр төлбөр	-	140,916,618.84
Богино хугацаат өр төлбөрийн дүн	487,314,748.78	759,439,028.31
Нөөц /өр төлбөр/		14,091,661.88
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	14,091,661.88
Өр төлбөрийн дүн	487,314,748.78	773,530,690.19
Өмч Хувийн	15,605,400.00	15,605,400.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,168,395,800.00	1,168,395,800.00
Эздийн өмчийн бусад хэсэг	620,993,000.00	620,993,000.00
Хуримтлагдсан ашиг	1,319,763,179.93	1,211,826,583.38
Эздийн өмчийн дүн	3,124,757,379.93	3,016,820,783.38
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,612,072,128.71	3,790,351,473.57

ЭРДЭНЭТ СУВРАГА ХК

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Орлогын дэлгэрэнгүй тайлан

Үзүүлэлт	/төгрөгөөр/	
	2023.12.31.	2024.12.31.
Борлуулалтын орлого	2,301,414,848.73	3,457,878,962.77
Борлуулалтын өртөг	1,564,226,398.82	1,556,071,626.78
Нийт ашиг/алдагдал	737,188,449.91	1,901,807,335.99
Хүүний орлого	1,812.63	3,160.69
Борлуулалт маркетингийн зардал	50,138,918.68	52,441,037.84
Ерөнхий ба удирдлагын зардал	675,519,939.07	1,816,978,154.84
Бусад зардал	234,289,814.37	-
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал	(222,758,409.58)	32,391,304.00
Орлогын албан татвар	1,153,140.49	3,239,130.40
Татварын дараах ашиг/алдагдал	(223,911,550.07)	29,152,173.60

ЭРДЭНЭТ СУВРАГА ХК

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн

Өмчийн Өөрчлөлтийн Тайлан

						/төгрөгөөр/
Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн	
2022 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	15,605,400.00	1,168,395,800.00	-	1,544,455,000.00	2,728,456,200.00	
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	620,993,000.00	-	620,993,000.00	
Залруулсан үлдэгдэл	15,605,400.00	1,168,395,800.00	620,993,000.00	1,544,455,000.00	3,349,449,200.00	
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(223,911,550.07)	(223,911,550.07)	
Зарласан ногдол ашиг	-	-	-	780,270.00	780,270.00	
2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	15,605,400.00	1,168,395,800.00	620,993,000.00	1,319,763,179.93	3,124,757,379.93	
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	
Залруулсан үлдэгдэл	15,605,400.00	1,168,395,800.00	620,993,000.00	1,319,763,179.93	3,124,757,379.93	
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	29,152,173.60	29,152,173.60	
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	(137,088,770.15)	(137,088,770.15)	
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	
2024 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	15,605,400.00	1,168,395,800.00	620,993,000.00	1,211,826,583.38	3,016,820,783.38	

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн бүрдэл хэсэг болно.

ЭРДЭНЭТ СУВРАГА ХК

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн

Мөнгөн Гүйлгээний Тайлан

Үзүүлэлт	2023.12.31.	/төгрөгөөр/ 2024.12.31.
Мөнгөн орлогын дүн	2,968,350,897.68	4,071,665,839.85
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,531,556,333.60	3,803,666,859.05
Бусад мөнгөн орлого	436,794,564.08	267,998,980.80
Мөнгөн зарлагын дүн	3,437,665,384.89	2,888,848,453.29
Ажиллагчдад төлсөн	157,625,152.94	177,484,760.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	50,026,690.99	51,601,900.00
Бараа материал авахад төлсөн	1,153,602,670.00	679,534,343.00
Ашиглалтын зардалд төлсөн	40,517,353.77	36,008,058.49
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	129,478,719.90	750,749,719.64
Хүүний төлбөрт төлсөн	43,907,004.07	114,105,794.37
Татварын байгууллагад төлсөн	63,882,825.63	37,954,938.28
Даатгалын төлбөрт төлсөн	573,655.00	-
Бусад мөнгөн зарлага	1,798,051,312.59	1,041,408,939.51
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(469,314,487.21)	1,182,817,386.56
Мөнгөн орлогын дүн	1,812.63	3,160.69
Хүлээн авсан хүүний орлого	1,812.63	3,160.69
Мөнгөн зарлагын дүн	158,869,749.25	436,392,750.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	153,424,249.25	133,745,000.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,445,500.00	1,147,750.00
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	301,500,000.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(158,867,936.62)	(436,389,589.31)
Мөнгөн орлогын дүн	2,268,000,000.00	6,946,800,000.00
Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан мөнгө	2,268,000,000.00	6,946,800,000.00
Мөнгөн зарлагын дүн	1,993,223,759.38	6,846,583,087.00
Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас төлсөн мөнгө	1,992,482,502.88	6,846,583,087.00
Төлсөн ногдол ашиг	741,256.50	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	274,776,240.62	100,216,913.00
Валютын ханшны зөрүү	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(353,406,183.21)	846,644,710.25
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	372,100,000.00	18,693,816.79
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,693,816.79	865,338,527.04